



СҮХБААТАР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2026 ОНЫ ЭХНИЙ
ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2026 ОН

АГУУЛГА

- Хүний нөөц
- Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр
- Хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр
- Хяналт шалгалтын чиглэлээр
- Үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр
- Өргөдөл гомдлын чиглэлээр
- Байгууллагын архив, бичиг хэргийн үйл ажиллагаа
- Нэгдсэн архивын чиглэлээр
- Мэдээлэл технологийн чиглэлээр
- Сургалт хамтын ажиллагааны чиглэлээр
- Нээлттэй хаалганы өдөрлөг
- Онцлох ажил
- Бусад
- Дүгнэлт



Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь Монгол улсын холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд Иргэний улсын бүртгэл, Хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг хуульд нийцүүлэн түргэн шуурхай, чанартай үзүүлэх үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

1. Хүний нөөцийн чиглэлээр

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 1-ний өдрийн “Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал зэрэглэлийг шинэчлэн батлах тухай” А/157 дугаар тушаалаар 26 орон тоо батлагдан төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх зарчмыг баримтлан ажиллаж байна. Тус хэлтэс нь сул орон тоог нөхөх ажлыг зохион байгуулж албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор Онгон, Наран, Баяндэлгэр, Эрдэнэцагаан, сумын бүртгэгч нарыг төрийн албаны тухай хуулийн дагуу шилжүүлэн томилогдож, Баяндэлгэр болон аймгийн иргэний улсын бүртгэгч нарыг төрийн албаны тусгай шалгалт зарлан томилуулан ажиллаа.

Аймгийн иргэний улсын бүртгэгчээр шинээр томилогдсон албан хаагч нь тус хэлтсийн архив, бичиг хэргийн эрхлэгч, няравын ажилтай байсан бөгөөд төрийн албаны тухай хуулийн мерит зарчмын дагуу томилогдон ажиллаж байна.

2. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасаг нь 2026 оны 1 дүгээр сараас 5 дугаар сарыг дуусталх хугацаанд Монгол улсын Үндсэн хууль, Улсын Бүртгэлийн Ерөнхий хууль, Гэр бүлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэл хөтлөх журам, Монгол улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх мэдээлэх журам болон холбогдон гарсан бусад дүрэм журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн Иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө хууль ёсны ашиг сонирхолыг хүндэтгэх, иргэний хувийн нууцыг чандлан хамгаалах зарчмыг баримтлан ажиллаж байна.

Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд хагас жилийн байдлаар 3295 бүртгэлийн 7897 хуудас бүхий нотлох баримт цахимжаад байна. Үүнээс төрсний бүртгэл 349, иргэний үнэмлэхний иуб-31 бүртгэл 1291, гадаад паспорт 940 бүртгэлүүд дийлэнх цахимжуулалтыг эзлэж байна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд “Үндэсний энгийн гадаад паспорт”-ыг заавал аймгийн төвд ирж, улсын бүртгэлийн хэлтэст захиалдаг байсан бол одоо тухайн харьяалах сумандаа шууд захиалан, хуулийн хугацаанд хүлээн авах боломж бүрдээд байна.

Энэхүү үйлчилгээ нь:

- Иргэдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх,

- Цаг хугацаа, эдийн засгийн зардлыг хэмнэх,
- Төрийн үйлчилгээг иргэдэд илүү ойр, хүртээмжтэй болгох чухал ач холбогдолтой

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг (нөхөн) хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 3/3951 дугаартай “Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтыг 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн дотор сонгуулийн хэсгийн хороонд хүргүүлэх”-тэй холбоотой зөвлөмжийг хүлээн авч сонгогчдын нэрийн жагсаалтыг 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдөр 09:00-12:00 цагийн хооронд 1 хувь хэвлэсэн.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг Сүхбаатар сумын хэсгийн хороонд (15-8-2) хүлээлгэн өгсөн тухай тэмдэглэл үйлдэн хэсгийн хорооны даргаар гарын үсэг зуруулж албажуулан хүлээлгэн өгсөн.


ИУБГ-аас 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 3/297 дугаарт “Нэмэлт өөрчлөлт, нөхөн бүртгэл шалгах тухай” чиглэлийн дагуу 2023, 2024, 2025 онуудад иргэний улсын бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулсан, нөхөн бүртгэсэн бүртгэлийг нэг бүрчлэн шалгаж илэрсэн зөрчлийг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэн ажиллаж байна.

3. Хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр



Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон түүнийг дагалдан гарсан журмууд, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, ХЭБГ болон ХШГ-аас ирүүлсэн чиглэл, зөвлөмжүүдийг бүртгэл хөтлөх үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

2026 оны 2 дугаар улирлын байдлаар иргэн, хуулийн этгээдээс нийт 187 өргөдөл хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн.

Улсын бүртгэлийн мэдээллийн санд 2-р улирлын байдлаар бүртгэгдсэн хуулийн этгээдийн тоон үзүүлэлт



Төрийн бус байгууллагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт зааснаар үйл ажиллагааны тайлангаа 02 сарын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлэх хуулийн хүрээнд 2025 оны үйл ажиллагааны тайланг хуулийн этгээдийн бүртгэл хийх эрхтэй бүртгэгч нар тухайн сумандаа хүлээн авч, бусад сумын бүртгэгч нартай хамтран төрийн бусын тайланг цаасаар болон цахимаар хүлээн авсан. Аймгийн хэмжээнд нийт 44 төрийн бус байгууллагын тайланг хүлээн авч цахимжуулан архивд хүлээн өгч байршуулаад байна.



Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 24 өдрийн А/217 тушаалаар хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх маягтын загварыг шинэчлэн баталж, 2026 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн. Иймд иргэн, хуулийн этгээдүүд улсын бүртгэлийн үйлчилгээ авахдаа шинэчлэн баталсан цаасан маягыг бөглүүлэн үйлчилж байна



2026 оны 02 дугаар сарын 01 ны өдрөөс Хуулийн этгээдийн тамга тэмдгийн хяналтын дугаарыг шинээр болон дахин олгохдоо E-Business системээс цахимаар захиалдаг болсон .

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018.11.01-ний өдрийн А/208 дугаар тушаалаар батлагдсан “Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам”-д заасны дагуу хуулийн этгээдийн салбарыг шинээр бүртгэх болон мэдээлэлд орсон өөрчлөлтийг хүлээн авч бүртгэн, бүртгэлийн эх нотлох баримт бичгийг дугаарлан цахимжуулж хувийн хэргийг нь харьяалагдах нэгжийн архивд шилжүүлэн ажилласан байна.

Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт нийт 34 бүртгэсэн байна.

Тамга, тэмдгийн хяналтын дугаар шинээр 63-г олгож, 13 хуулийн этгээдээс тамга тэмдгийг хураан авч архивчид хүлээлгэн өгөв.

Иргэн хуулийн этгээдийн өргөдөл, хүсэлтээр хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 19 лавлагаа олгосон байна.

Иргэдэд эрх зүйн мэдлэг олгох, байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор Улсын бүртгэлийн хууль тогтоомж, мэдээ мэдээллийг олон нийтийн цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд сурталчлан ажилласан.

Хууль зүйн сайдын 2018.02.13-ны өдрийн А/24 дүгээр баталсан “Салбарын статистик мэдээллийн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журам” –ын дагуу

сар бүр хуулийн этгээдийн тоон мэдээг хугацаанд нь тогтмол гаргаж ХЭБГ-т хүргүүлэн ажилласан.

Аж ахуй нэгжийн тооллого явуулах комиссын гишүүнээр аймгийн засаг даргын 2026 оны 02 сарын 10 ны өдрийн А/74 тоот захирамжаар томилогдон тооллогод хамрагдах аж ахуй нэгж байгууллагыг бүрэн хамруулах талаар аймгийн статистикийн хэлтэстэй хамтран ажиллаж , хуулийн этгээдийн санд бүртгэлтэй мэдээллийг тулгаж нэгтгэж хамтран ажилласан.



4. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл

Тайлант хугацаанд нийт 2353 мэдүүлэг хүлээн авч 10356 хуудасыг цахим санд цахимжуулсан. Мөн 6 суманд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрхтэй бүртгэгч нар 2026 оны хагас жилээр нийт 238 бүртгэл хөтөлсөн.

Хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн эрх түдгэлзүүлсэн тухай 4 албан бичгээр 7 үл хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлэх, эрх сэргээх тухай 8 албан бичгээр ирүүлсэн албан хүсэлтийг үндэслэн 8 үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг сэргээх бүртгэлийг мэдээллийн санд бүртгэж ажилласан.

“Монголын ипотекийн корпорац”-ийн 2025 оны 25/25, 25/39 тоот албан бичгүүдийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багц”-ыг тусгай тэмдэглэл хийж бүртгүүлэхийг хүссэн хүсэлтийг хүлээн авч худалдах, худалдан авах гэрээнд / ипотекийн зээл/ тусгагдсан 4 банкны 114 ширхэг эд хөрөнгөнд тусгай тэмдэглэл хийж, мэдээллийн санд бүртгэж хариуг хугацаанд нь хүргүүлж ажиллав.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас хууль хяналтын байгууллагад 48 хуулийн этгээдийн лавлагаа хуулбарыг олгож ажилласан. УБЕГ-ын даргын 2026.03.23-ны өдрийн 1352 тушаалын дагуу 1 газар, 1 үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийг хаах бүртгэлийг мэдээллийн санд бүртгэж ажиллав.

УБЕГ-ын даргын 2026.03.06-ны өдрийн 1164 тоот чиглэлийн дагуу ХУБ-ийн дүгнэлтээр үрэгдүүлсэн 11 газар 4 үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх гэрчилгээг хүчингүйд тооцож шинээр гэрчилгээг бичиж олгосон.

Хагас жилийн байдлаар нийт үйлчилгээний хураамж-30,454,241 төгрөг Тэмдэгтийн хураамж -2.523.389 төгрөг, ҮХЭХӨЭ-ээ худалдсанаас оруулсан татварын орлого-340,042,460 төгрөгийн орлого оруулсан байна.

5. Хяналт шалгалтын чиглэлээр

Улсын бүртгэлийн ерөнхий хууль заасан бүртгэлийн үйл ажиллагаа болон улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна. 2026 оны 01 дүгээр сарын 01- нээс 2026 оны 06 дугаар сар хүртэл эхний улиралд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 2400, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 238, иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 425 бүртгэлд хяналт шалгалт хийж УБЕГ-ын даргад илтгэх хуудсаар танилцуулан ажиллаа.

Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль зэрэгт заасан үндэслэл журмаар нийт 28 бүртгэлд хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргаж шийдвэрлэсэн. Мөн иргэний улсын бүртгэлийн тухай хууль, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль зэргийг зөрчсөн нийт 197 иргэн болон аж ахуй нэгж хуулийн этгээдэд зөрчлийн тухай хуульд зааснаар 4,260,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан байна.

2026.03.19 нд Онгон, Наран суманд томилолтоор ажиллаж иргэдэд үйлчилж байгаа алба хаагчийн бүртгэлд хяналт тавих, хяналт шалгалттай холбоотой иргэдээс гаргах санал хүсэлт байгаа эсэх талаар 26 иргэнтэй уулзаж ажилласан. Ямар нэг санал гараагүй. 2026.05.14-нд Онгон суманд ажиллаж Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулж байгаа “ Иргэндээ ээлтэй бүртгэлийн үйлчилгээ” аяны хүрээнд иргэний бүртгэлийн чиглэлээр 3 иргэнтэй уулзаж хугацаа хэтэрсэн зөрчилтэй байсныг дүгнэлтээр засварлаж дахин бүртгэлийг хийлгэсэн. Мөн аяны талаар 30 иргэнд сурталчилсан. Сүхбаатар суманд нөхөн сонгууль болж байгаатай холбогдуулж 2026 оны 05 дугаар сарын 21 ны өдрийн 3/3951 дугаартай зөвлөмжийн дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ямар нэг зөрчилгүй ажилласан.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, иргэний улсын бүртгэлийн EPRS2 программын цахим мэдээллийн санд цахимжуулан оруулж байгаа мэдээллийг хянан шалгах цаасан эх нотлох баримттай тулгах хуульд заасан урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг төлөвлөгөөнд тусгасаны дагуу тогтмол хийж гүйцэтгэж байна.

Зургаа. Үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр

“E-Mongolia” цахим системээр дамжуулан 22 төрлийн лавлагаа, 50 төрлийн үйлчилгээ үзүүлж байна.Үүнд иргэний улсын бүртгэлийн 26 төрлийн үйлчилгээ, 12 төрлийн лавлагаа, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 13 төрлийн үйлчилгээ, 7 төрлийн лавлагаа, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 9 төрлийн үйлчилгээ, 3 төрлийн лавлагааг тус тус цахимаар үзүүлж байна.Улсын бүртгэлийн байгууллага Засгийн газрын 2020 оны “Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 230 дугаар тогтоолыг 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн ба тус тогтоолоор лавлагааг үнэ төлбөргүй олгохоор тусгасан. Үүнтэй холбоотойгоор лавлагааг цахимаар, үнэ төлбөргүй авах болсон нь иргэн, хуулийн этгээдээс гарах зардал хэмнэгдэх боломж бүрдсэн.

Мөн Сүхбаатар аймаг дахь төрийн цахим үйлчилгээний хэлтэстэй хамтран 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдөр “ОНЦЛОХ 10-Н ҮЙЛЧИЛГЭЭГ СУРТАЛЧИЛАХ” нээлттэй хаалганы өдөрлөгийн Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Нэгдсэн үйлчилгээний цэгт зохион байгуулж хамтран ажиллаа. Дээрх 10 үйлчилгээний эхний 2-т улсын бүртгэлийн байгууллагаас олгогддог төрсний бүртгэлийн болон шилжилт хөдөлгөөний лавлагаа эзлэж байгаа бөгөөд дээрх 2 төрлийн лавлагааг хэрхэн хурдан системээс авах тухай заавар зөвлөгөөг өгч ажиллаа.


Албан хаагчдыг мэдлэг мэдээлэлээр хангах 15 удаагийн сургалтыг танхимаар болон цахим хэлбэрээр зохион байгуулан явуулаад байна.

Хэлтсээс иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж, ажилтнуудын харилцаа хандлага, үйлчилгээний шуурхай байдлын талаарх хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг тодорхойлох судалгааг QR код үүсгэн зохион байгуулсан. Судалгаанд 35-45 насны нийт 54 иргэн хамрагдсан байна.



Сэтгэл ханамжийн судалгааны үр дүн

Нийт 54 иргэний үнэлгээ



Судалгаанд оролцсон иргэдийн үнэлгээг нэгтгэн үзэхэд:

- "Маш сайн" үнэлгээ – 38 хүн буюу 70.4 хувь
- "Сайн" үнэлгээ – 16 хүн буюу 29.6 хувь
- "Дунд" үнэлгээ – 0 хүн
- "Муу" үнэлгээ – 0 хүн

- "Маш муу" үнэлгээ – 0 хүн байна.

6. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт

2026 оны нэг дүгээр улирлын байдлаар албан хаагчдаас нийт 5 хүсэлт ирүүлж хүсэлтийг шийдвэрлэн УБЕГ руу хүргүүлэх шаардлагатай 3 албан хаагчийн хүсэлтийг албан бичгээр хүргүүлсэн байна.

Тус хэлтэст иргэд олон нийттэй харилцах төвийн 11-11-с ирсэн өргөдөл болон гомдол байхгүй болно.

Өргөдөл гомдлын сар, улирлын мэдээг гарган УБЕГ руу илгээж ажиллаж байна. Хугацаа хоцроосон буруу, зөрүүтэй гаргасан мэдээлэл байхгүй болно.

2026 он гарсаар албан хаагчид болон аж ахуй нэгж, иргэнээс нийт 14 өргөдлийг хүлээн авч бүртгэн хуулийн хугацаанд нь шийдвэрлүүлсэн байна

7. Байгууллагын архив бичиг хэргийн үйл ажиллагаа

2026 оны 05 сарын байдлаар ERP программаар дамжуулан Улсын бүртгэлийн ерөнхий газар болон бусад агентлаг албадаас 201 албан бичгийг хүлээн авч бүртгэл хөтлөн албан хэрэг хөтлөлтийн программд хариуцсан албан хаагчид руу шилжүүлж хариу хүргүүлэх шаардлагатай 150 албан бичиг хариу хүргүүлж, 192 албан бичгийг цахим системээр дамжуулж илгээсэн байна.

Монгол хэлний тухай хууль, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолын дагуу 2025 оны 01 дүгээр сараас эхлэн албан хэрэг хөтлөлтийг крилл болон үндэсний хос эгшигээр хослуулан бичихтэй холбогдуулан тус хэлтэс нь 2025 оны

01 дүгээр сараас эхлэн албан бичиг, болон захирамжлалын бичгийг крилл болон хос бичгээр хослуулан бичиж хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Байгууллагын архивт байнга хадгалах 137, түр хадгалах 125, 70 жил хадгалах 41 баримт цаасан суурьт хадгаламжийн нэгжийг ажиллах хүлээлцэх комиссын гишүүдийн хамт тооллого хийн архивт нийт 303 баримтыг тоолж дуусгасан түр хадгалах 125 баримтаас хадгалах хугацаа дууссан 67 баримтыг устгахаар акт үйлдэн хэлтсийн даргад танилцуулж устгах хэргийн актыг батлуулан ажил хүлээн авсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/100 дугаартай тушаалаар батлагдсан “БАЙГУУЛЛАГЫН АРХИВЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТЛЭГ ЖУРАМ”-аар шинэчлэгдсэн маягтуудын дагуу өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглагддаг баримтын бүртгэл, данс бүртгэлийн маягтуудыг өөрчлөн ажилласан.

Байгууллагын архивын ажилтан үлгэрчилсэн жагсаалтын дагуу зохион байгууллалтын нэгж ажилтан албан хаагчдаас удирдлагын түвшинд үүсч хөтлөгддөг баримтуудыг ХХНЖ-ын дагуу эмхлэн цэгцлүүлж архивт шилжүүлэн ажиллаж байна. Мөн 2009-2024 оны баримтад нэг бүрчлэн нягтлан шалгалт хийж нийт 2009-2024 оны 180 гаруй баримтыг ангилж цэгцэлж янзалсан. Тооллогоор байгууллагын архивт түр хадгалах 125 хадгаламжийн нэгжээс хадгалах хугацаа дууссан эрдэм шинжилгээний ач холбогдолгүй болсон 67 баримтыг түүвэрлэн авч устгахаар БНШК-ын 2025 оны 03 тоот хурлаар хэлэлцүүлж устгалд оруулахад бэлэн болсон байна. Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцлийг сайжруулах тоо бүртгэл, эрэл хайлт, ашиглалтын үйл ажиллагааг хөнгөн шуурхай болгох, эх баримтыг ашиглалтаас чөлөөлөх зорилгоор 2009-2024 оны нийт 59, байнгын 45 баримт нийт 104 баримтыг цахим хэлбэр шилжүүлж цахим мэдээллийн санг үүсгээд байна.

Захиргааны ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу захиргааны шийдвэр бүрд хяналтын дагалдах хуудас хавсаргаж байгаа бөгөөд дагалдах хуудсанд захиргааны шийдвэр боловсруулахад оролцсон албан хаагч бүрийн нэр, албан тушаал, оролцоо, тэмдэглэж хэвшсэн. 2026 оны 05 дугаар сарын байдлаар нийт 14 тушаалд хяналтын дагалдах хуудсыг бүртгэн хавсаргасан байна. 2009-2024 онуудын захирамжлалын баримт бичгүүдийг хавсралтын хамт он оноор нь хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын индексээр дугаарлан цахим архив үүсгэсэн.

“Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль”-ийн 27.1, 27.1.11-д заасны дагуу Төрийн архивын сан хөмрөгт шилжүүлэх архивын баримтыг байгууллага 8 жил хадгалж хугацаа дуусмагц түүх, эрдэм шинжилгээний ач холбогдлоор ангилан 2026 оны 02 дугаар улиралд багтаан аймгийн төрийн архивт 2009-2018 оны байнга хадгалах хадгаламжийн 50 баримтыг ангилан данс бүртгэл үйлдэн ажилласан.

8. Нэгдсэн архивийн үйл ажиллагааны чиглэлээр

2026 оны 2 улирлын байдлаар эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын хувийн хэрэг энэ улиралд газраас бусад үл хөдлөх 9209, газар 8969, нэмэгдэж эд хөрөнгийн хувийн хэрэг 18169 болж архивт хадгалагдаж байна. Архиваас түр олгосон захиалгын хувийн хэрэг 56 эд хөрөнгийн хувийн хэргийн хавтас 83 хувийн хэргийн хавтас сольсон Хувийн 112 хайрцаг сэлбэн зассан. Хуулийн этгээдийн

архивын аж ахуй нэгж хувийн хэрэг 2143 архивт хадгалагдаж шинээр бүртгэгдсэн аж ахуй нэгж 47, мэдээлэл өөрчлөлт 45, хувийн хэрэг ERS системээр цахим архивт бүртгэж, эх нотлох баримт цаасан хувийн хэрэг 126 баяжилтыг архивт байршуулж ажилласан байна. Аж ахуй нэгжийн хүчингүй болон хураагдсан 5 хураан авсан. Архивт хадгалагдаж байгаа татан буугдсан 74, хасагдсан хуулийн этгээд 95, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 44 хувийн хэргийг хавтаслаж дугаарлаж цэгцлээд байна.

Архивын баримт, хувийн хэргийн чийгшилт, халуун, хүйтнийг стандартын дагуу ханган хадгалах чийг дулаан хэмжигч, байрлуулж тэмдэглэл хөтлөсөн.



Хагас жилийн байдлаар төрсний бүртгэл 54, гэрлэлтийн бүртгэл 48, нас баралт 13, үрчлэлт 8, ширхэг бүртгэлийн журнал шүүн нөхөн бүртгэлд хамруулж ажиллалаа.



Улсын бүртгэлийн хэлтсийн ерөнхий газрын тушаал болон хэлтсийн даргын тушаалаар эд хөрөнгө эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийн тооллогын үйл ажиллагаа 5 сарын 20 наас эхлэж тооллогын ажилд сумдын улсын бүртгэгч, нарыг татан оролцуулаад байна



9. Мэдээлэл технологийн чиглэлээр


Нийт 41 удаа хэрэглээний болон мэргэжлийн программ хангамж суулгасан.

Компьютер, принтер болон бусад тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ нийт 19 удаа хийсэн. Ашиглагдаж буй тоног төхөөрөмж бүгд хэвийн ажиллаж байна.



Дотоод сүлжээ болон сүлжээний аюулгүй байдлыг хянах зорилгоор дотоод сүлжээг шаардлагатай байрлалаар зохион байгуулж сүлжээний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Сүхбаатар аймгийн 13 сум, хэлтсийн хэмжээнд бүртгэлийн ерөнхий сүлжээ нь Мэдээлэл холбоо сүлжээ ТӨК-ын сүлжээгээр хангагдаж ажиллагаа бүрэн хэвийн ажиллаж байна.

Хэлтсийн байрны дотоод сүлжээний рүүтер төхөөрөмж болон интернэтийн свитч төхөөрөмж цахилгааны саатлын улмаас шатсаныг шинээр сольж мөн Баруун-Урт сумын шилэн кабелийн А Б конвертор цахилгааны саатлын улмаас шатсаныг шинээр сольсон. Наран сумын дотоод сүлжээний зохион байгуулалтыг шинэчилж шинээр томилогдсон Улсын бүртгэгчийн бүртгэлийн үйл ажиллагаа хэвийн ажиллах боломжтой болсон.



Мэдээ мэдээллийн ил тод байдал

Мэдээлэл түгээж буй сувгууд

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс www.sukhbaatar.burtgel.gov.mn


Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс <https://www.gov.mn/org/suhbaatar-burtg>

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс www.facebook.com/sukhbaatarburtgel


Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой 54 мэдээ мэдээлэл бэлтгэн вэб сайт болон фэйсбүүк цахим хуудсаар мэдээлсэн.

Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган санхүүгийн тайлан, ажлын байрны шинэ зар, жил улирлын тайлан, статистик тоон мэдээ, өргөдөл гомдлын мэдээ, төсвийн гүйцэтгэлийн мэдээ зэргийг сар бүрээр тогтмол вэб сайт болон фэйсбүүк фэйжид байршуулж байна.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын фэйсбүүк хуудсаар оруулсан нийт 77 мэдээ мэдээллийг өөрийн фэйсбүүк хуудсаар дамжуулан дахин шэйрлэж түгээсэн.



Төрийн үйл ажиллагаан ил тод, нээлттэй байлгах, олон нийтийн хяналтыг бий болгох зорилготой нээлттэй мэдээллийн систем www.shilen.gov.mn тайлан мэдээ мэдээллийг 2026 оны 1-р сараас эхлэн Төрийн байгууллагын цахим хуудас www.gov.mn –д шинээр хөгжүүлж 2026-03-31 дөр 1-р улирлын тайланг илгээж 100% үнэлэгдсэн.



10.Сургалт, хамтын ажиллагаа

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2026 оны А/94 дүгээр тушаалаар баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу хэлтсийн 2026 онд зохион байгуулах сургалтын дэд төлөвлөгөөг 7 арга хэмжээ, 46 ажил үйлчилгээний дагуу төлөвлөн батлуулж, төлөвлөгөөний дагуу эхний хагас жилд 15 сургалтыг зохион байгуулаад байна. Бусад сургалтууд хугацаа нь болоогүй хүлээгдэж байгаа болно.

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс тус аймгийн Прокурорын газрын Ахлах прокурор, хууль цаазын ахлах зөвлөх О.Эрхэмбаяртай хамтран 2026-01-15 өдөр

1. “Гэмт хэргийн нөхцөл байдал, анхаарах асуудал”,
2. “Зарим төрлийн гэмт хэрэг, зөрчлийн эрх зүйн зохицуулалт”,
3. “Авилгын гэмт хэрэг, эрх зүйн зохицуулалт”,
4. “Зөрчлийн мэдээллийн цахим сангийн хэрэглээ”

сэдвүүдийн хүрээнд мэргэжил арга зүйн сургалт, нөлөөллийн арга хэмжээг танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулж, хэлтсийн болон сумдын улсын бүртгэгчид бүрэн хамрагдлаа.



Төрийн албаны Сүхбаатар аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга М.Оюунтөгстэй хамтран “Төрийн албан хаагчийн ёс зүй”-н чиглэлээр сургалт, мэдлэг ойлголт олгох, нөлөөллийн арга хэмжээг онолын болон харилцан ярилцах хэлбэрээр зохион байгууллаа. Сургалтад хэлтсийн албан хаагчид танхимаар, сумын улсын бүртгэгчид цахимаар бүрэн хамрагдлаа.



Сүхбаатар аймгийн Стандарт хэмжил зүйн газраас Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага MNS 7068:2025 сэдэвт сургалтыг 2026.02.10-ны өдөр зохион байгууллаа. Сургалтад төвийн албан хаагчид танхимаар сумдын албан хаагчид цахимаар хамрагдав.



Цаашид төлөвлөгөөнд заагдсан цаг хугацааны дагуу сургалтыг зохион байгуулан ажиллахаар төлөвлөж байна.

11.Нээлттэй хаалганы өдөрлөг

Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын Тамгын газартай хамтран 2026.03.27 өдөр иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх “Нээлттэй өдөрлөг” зохион байгуулсан.

Нээлттэй өдөрлөгийн хүрээнд:

- ✓ Үндэсний энгийн гадаад паспортын захиалга – 17
- ✓ Иргэний цахим үнэмлэхийн захиалга - 14
- ✓ Төрсний бүртгэл - 1
- ✓ Нас барсны бүртгэл -1 бүртгэлээ.

- ✓ Үл хөлдөх хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 6 бүртгэл, газар өмчлөлттэй холбоотой бүртгэлийн 5 гэрээ хэлцэл хүлээж авсан.
- ✓ Үл хөлдөх хөрөнгийн барьцаат зээл - 3
- ✓ Газар өмчлөлийн 2 барьцаат зээлийн гэрээ бүртгэсэн.
- ✓ 20-иод иргэдэд газар өмчлөл болон гэрээ хэлцэл хийх талаар зөвлөгөө зөвлөмж өгч ажиллаа.



Монголын хуульчдын холбооноос нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүрийн 05 дугаар сарын 01-ний өдрийг Хууль зүй, дотоод хэргийн яам болон түүний харъяа агентлаг, байгууллагуудтай хамтран зохион байгуулж хэвшсэн “Хуульчийн Про Боно өдөр” буюу хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг сурталчилж таниулах, хууль зүйн зөвлөгөөг үнэ төлбөргүй өгөх өдрийг нийтэд зарлан, тэмдэглэн өнгөрүүлдэг.

Тус “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийн арга хэмжээнд Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс оролцож Иргэний, Хуулийн этгээдийн, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, архивын лавлагаа, улсын бүртгэлийн талаарх мэдээлэл зөвлөгөөг өгөх үйлчилгээг иргэдэд газар дээр нь хүргэсэн.



Сүхбаатар аймгийн зэвсэгт хүчний 338 дугаар цэргийн ангийн ажилтан, албан хаагчдад төрийн үйлчилгээг ойртуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс улсын бүртгэлийн үйлчилгээг зөөврийн тоног төхөөрөмжөөр хүргэн тоон гарын үсэг 4 иргэнд, гадаад паспортын захиалга 3 иргэнд, иргэний үнэмлэхийн 88 лавлагааг цэргүүдэд олгох ажлыг зохион байгуулж ажиллаа.




Сүхбаатар аймгийн ХААН банк цаасгүй, цахим хэрэглээг харилцагчдадаа өдөр тутам санал болгодог бөгөөд 2026 оны 5 сарыг дуустал долоо хоног бүрийн 2 дох өдрийг “ЦАХИМ ӨДӨР” болгон ажиллаж байна. Уг цахим өдрийн хүрээнд Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс зөөврийн бүртгэлийн төхөөрөмж ашиглан иргэдэд төв салбар дээр тоон гарын үсгийг 11 иргэнд олгон ажиллаж байна.

12. Онцлох ажил

Болроогоос онцлох ажил нэмээд ерөнхийдөө болно.

13.Бусад

Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын салбарын хэмжээнд 2026 оны 03 дугаар сарыг 'Жендерийн эрх тэгш байдлыг хангах сар' болгон зарлаж, 'Харилцан хүндэтгэе' аяныг зохион байгуулж сэдвийн хүрээнд 1, ажлын байрны өглөөний дасгалын 2, олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн 2 цахим контент бүтээж Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим хуудас болон бусад мэдээлэлийн сувгуудаар түгээн ажиллаа. Улсын бүртгэлийн brandbook-ын бүх загварын эх бэлтгэлийг хийж хэвлүүлсэн



Арав. Дүгнэлт

Тайлант хугацаанд тус аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь Монгол улсын холбогдох хууль, тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж, иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг хуульд нийцүүлэн, түргэн шуурхай, чанартай үзүүлэхэд анхаарч ажилласан байна.

Үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар үр нөлөөг дээшлүүлэхийн тулд 11 суманд гадаад паспортын захиалга, Асгат, Эрдэнэцагаан, Уулбаян, Халзан, Мөнххаан, Дарьганга сумдад Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлдэг болсон нь төрийн үйлчилгээний чанар үр нөлөөг дээшлүүлсэн үзүүлэлттэй байгаагын дээр иргэдийн цаг, эдийн засгийг бодитойгоор хэмнэсэн үйл явдал болсон.

Цаашид хүний нөөцийг чадвахжуулах, төрийн үйлчилгээг иргэн, аж ахуй нэгжид түргэн шуурхай хүргэх, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр тасралтгүй ажиллах шаардлагатай байна.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН

ЗАХИРГААНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.ОДОНЗУЛ

ТАЙЛАН ХЯНАСАН

СҮХБААТАР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.МӨНХЧИМЭГ

